

ФИЛИППИН - ИСПАНИЙ ХААНЫ НЭРЭЭР НЭРЛЭГДСЭН УЛС

Л.Бэгзжав

Эргэн тойрон далайгаар хүрээлэгдэн Зүүн өмнөд Азид орших томоохон арлын улс Бүгд Найрамдах Филиппин улс бол гадаад хүний нэрээр улсаа нэрлэгдсэн цорын ганц Азийн улс юм¹. Азийн эх хуурай газраас нүүж очсон нутгийн суугуул овгийнхон болон малай үндэстэний нүүдэлчин иргэд оршин сууж байсан энэ газар 1521 оны 3-р сарын 17-нд Испаний далайчин Ф.М.Магелланы удирдсан 5 усан онгоц зангуугаа хаяж газардсанаар испаничууд Филиппинд суурьших эхлэлийг тавьжээ. 1542 онд испаничууд энэ хавийн бүлэг арлыг хүчээр эзэмших болж, Испаний Филипп II хааны нэрээр *Isles Filipines* буюу “Филиппийн арал” гэж нэрлэсэн түүхтэй аж². Филиппиний бүлэг арал дээр том, бага 7107 арал байдагийг тогтоосон ч 4 мянга гаруй нь нэргүй, ердөө 460 гаруй нь нэртэй аж³. Тэдгээрээс Лусан, Минданао, Самар зэрэг 11 арал тус улсын 299404км² газар нутгийн 96 хувийг эзэлдэг бөгөөд нийт арлын арваны ес нь хүн оршин суудаггүй, эзэнгүй арлууд ажээ.

Эртний франц, латин, грек хэлэнд буюу өнөөгийн итали, испани, герман, голланд, орос, америкт өргөн тархсан Филипп гэдэг нэр нь грек хэлний *Philippos* буюу *philos* хайртай, дуртай + *hippos* - морь гэсэн үгнээс гаралтай “моринд хайртай хүн” гэсэн утгатай байна⁴. МЭӨ IV зууны үеийн Александр Македон хааны элгийн нэр Филипп, Библийн сударт гардаг Христосын 12 шавийн нэгийг Филипп хэмээдэг билээ.

Филиппиний арлууд дээр Испаничууд 300 гаруй жил ноёрхож, филиппиний ард түмний удаа дараагийн тэмцэл, 1898 оны 4-р сард эхэлсэн Америк Испаний дайны нөлөөгөөр мөн оны 6-р сарын 12-нд Филиппиний тусгаар тогтнолыг анх зарлажээ. Энэ өдрийг одоо ч тусгаар тогтнолын өдөр буюу үндэсний баяр хэмээн Филиппинд тэмдэглэдэг. 1898 оны 10-р сард Америк Испанийн дайн дуусч 12-р сарын 10-нд “Парижийн гэрээ” гэгчид хоёр тал гарын үсэг зурснаар Испани улс Америкт 20 сая ам.доллар төлж, Филиппинийг Америкт өгсөн юм.

1941 оны 12-р сарын 8-нд Япон улс Америкийн цэргийн гол бааз Пёрл Харборд довтолж, улмаар хэдхэн цагийн дотор Японы

¹Л.Бэгзжав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор (Ph.D), дэд профессор

онгоцууд Филиппинийг бөмбөгдөж Америкийн далайн цэргийн түшиц газруудыг устган улмаар 1942 оны 1-р сараас тус оронд ноёрхлоо тогтоосон байна. Дэлхийн 2-р дайны дараа Филиппин дахин АНУ-ын нөлөөнд орж, 1946 оны 7-р сарын 4-нд тусгаар тогтнолоо 2 дахь удаагаа тунхаглаж, “Америк-Филиппиний харилцааны ерөнхий гэрээнд” гарын үсэг зурав. 1947 онд “Америк Филиппиний цэргийн баазын хэлэлцээр” ёсоор Филиппинд 23 цэргийн баазыг 99 жилийн хугацаагаар түрээслэх болжээ.

2000 оны байдлаар, 75,3 сая хүн амтай, хүн амын 85 хувиас дээшхийг тагал, илова, банваня, висайя, викар зэрэг үндэстэн, мөн хятад, индонез, араб, энэтхэг, испани, америк, цөөн тооны суугуул үндэстэн байдаг. Хүн амын бараг 90 орчим хувь нь христос шашин шүтдэгээс ихэнх нь католик шашинтай. 4,9 хувь нь ислам шашин шүтдэг.

Зүүн өмнөд Азийн орнуудад хүний санаанд оромгүй олон хэл, аялгуугаар ярилцдаг. Индонезид 669, Малайз ба Филиппинд 150 гаруй, Бирмд 101, Лаост 90, Тайландад 80, Вьетнамд 76 Сингапурт 24, Бруней ба Кампучид 17 харилцан адилгүй, нутгийн хэл, аялгуугаар ярьдаг байна.⁵ Филиппин хэлийг суурь болгосон тагал хэл улсын хэл болдог ба англи хэлийг нийтлэг хэрэглэдэг байна. Филиппинд Энэтхэгийн соёлын нөлөө ихтэй. “Рамаяна”, “Махабрата” зэрэг энэтхэгийн алдарт туульс аман зохиолд нь ул мөрөө гүнзгий үлдээжээ. Тус орны албан ёсны тагал хэлний үгсийн сангийн 25 хувь нь санскрит хэлнээс орсон үг байдаг байна. Филиппиний соёлыг Хятад, Японтой харьцуулахад ихээхэн ялгаатай.

Филиппинд бүр VII зууны үеэс Хятадын Фузянь, Гуандун мужаас шилжин суурьшсан хятадуудын удам нэг сая 200 мянга гаруй хятад цагаач байдаг⁶. Тэд буддын шашин шүтдэг, 90 шахам хувь нь томоохон хотуудад худалдаа наймаа эрхэлдэг. Филиппин хүний 20 хувь, /заримдаа 30-40% нь/ хятад цустай гэж ярьдаг ба тус улсын түүхэнд нэрд гарсан хятад гаралтай олон хүн байдаг. Тухайлбал, Филиппиний үндэсний баатар, тусгаар тогтнолын хөдөлгөөний удирдагч, нэрт яруу найрагч Кеси Личагийн өвөг дээдэс нь Фузянь мужийнх, 1983-1992 онд Филиппины ерөнхийлөгч асан Каросон Акиногийн өвөг дээдэс Фузянь мужийн Лунхай хошууных гэх мэт.

Филиппиний хятад гаралтай иргэд үндэсний баяраа тэмдэглэж, “Shijie ribao”, “Feihua shibao”, “Shang bao”, “Lianhe ribao” зэрэг сонин хэвлэлийг хятад хэлээр гаргаж, хятад хэлний сургууль эрхэлдэг байна.

Филиппин “наргил модны орон” гэж алдаршсан газар юм. Дэлхийн зах зээлд нийлүүлдэг наргил модны бүтээгдэхүүний 60 орчим хувийг энд үйлдвэрлэдэг. Наргил модны тариалах талбай нийт тариалангийн талбайн 20 хувиас дээшхийг эзэлдэг, хүн амын гуравны нэг нь наргилын аж ахуйд түшиглэж амьдардаг.

Халуун бүсийн борооны улиралтай, жилийн турш чийглэг дулаан уур амьсгалтай, халуун бүсийн нэг түм гаруй зүйлийн ургамал, жимс алаглан ургадаг Филиппинийг гадаадын жуулчид “Номхон далайн цэцэгсийн хүрээлэн”, “жимсний орон”, “Азийн гадил жимсний хаант улс” гэх зэргээр эрхэмсэгээр өргөмжлөх нь бий. 1999 онд тус оронд 2 сая 170 мянган жуулчин очсон⁷ бөгөөд жуулчлал бол Филиппиний гадаад валютын чухал нэг эх сурвалж болдог байна.

Филиппинд 52 галт уул байдгаас 11 нь оргилж буй галт уулс юм. Минданао арлын өмнө хэсгийн Апо уул далайн түвшинээс дээш 2953 м өндөр бөгөөд тус орны хамгийн өндөр энэ оргил, сүүлийн 100 орчим жил оргилсоор байгаа аж. Лусон арлын Зүүн өмнөд хэсгийн Майон галт уул далайн түвшингээс дээш 2416 м өндөр, эргэн тойрны нийт бүслүүрийн хэмжээ нь 138 км, конус хэлбэртэй одоо оргилж буй хамгийн том энэ уул XIX зуунаас хойш 28 удаа дэлбэрч, 1814 онд бүхэл бүтэн хот тосгоныг үгүй болгож, XX зуунд ч хэд хэдэн удаа, хамгийн сүүлд 1993 онд дэлбэрч байжээ. Иймээс ч Филиппинийг “галт уулсын орон” гэж нэрлэх нь бий.

Тус оронд усан тээвэр их хөгжсөн. 1997 оны байдлаар 267,960 хөлөг онгоцоор 274 сая т ачаа тээвэрлэжээ. Филиппинд 1425 том бага боомт байдгаас хамгийн том боомт нь нийслэл Манила. 1997 оны байдлаар 192 нисэх онгоцны буудалтайгаас 89 нь улсынх, үлдсэн нь буюу 103 нь хувийнх юм. Мөн 27900 км² урт, авто замтай, нийт 262 км урт 7380 гүүртэй, 1998 оны байдлаар 2 сая 558 мянган автомашинтай байв.

Филиппин улс бэлэн хувцас, хагас дамжуулагч, зэс /зэсийн нөөцийн хэмжээ нь 3 тэрбум 716 сая тонн/ наргилын бүтээгдэхүүн, үнэт мод, далайн хясаа зэргийг экспортлодог болно. Дэлхийн 150 гаруй оронтой худалдаа хийдгээс гол зах зээл нь АНУ, Япон, ЕЭЗХН, Зүүн өмнөд Азийн орнууд байдаг.

Гадаад бодлогодоо бие даасан бодлого баримталдаг Филиппин улс тэнцвэртэй, тэгш эрхтэй, харилцан ашигтай, харилцан хүндэтгэсэн үндсэн дээр бүхий л улс орнуудтай улс төр, эдийн засгийн харилцаа хөгжүүлж байна. Филиппиний гадаад бодлогын 3 том зорилт гэвэл

аюулгүй байдлаа зузаатгах, эдийн засгийн хөгжлөө ахиулах, хилийн чанад дахь филиппин иргэдээ хамгаалах явдал байдаг. Манай улс Бүгд Найрамдах Филиппин улстай 1973 оны 10-р сарын 11-нд дипломат харилцаа тогтоосноос хойш энэ онд 30 жилийн ой тохиож байна.

Ишлэл зүүлт

1. Shijie geguo guoming jijin. Бээжин. 1987. 14-р тал.
2. Zhougguo zhoubian guojia gainian. Бээжин, 1994. 562-р тал.
3. Юго-Восточная Азия. М., 1986. с.256.
4. Словарь Английских личных имен, М., 1973. стр 287.
5. Campus Verlag /Герман/. Xin yazhou-yazhou tiaozhan shijie /хятад хэлээр/ Бээжин. 1998. 147-р тал.
6. Жан Хуа. Dongnanya huaqiao huaren. Lishi yu xian zhuan. Бээжин. 2001. 218-р тал.
7. Geguo gaikyan /yazhou/. Бээжин, 2002, 77-р тал.

Жич: Манай оронд гадаад орон судлалын ном, сурах бичиг, лавлах ховор, бараг үгүй, байгаа ганц нэг нь нэн хуучирсан, алдаа мадаг ихтэй байна. Ганц жишээ авбал: “Монголын нэвтэрхий толь”, УБ, 2000, II ботид Филиппин улсын тухай бичсэн 50-иадхан мөрөнд даан ч олон мадаг байгаагаас тоймтой ганц нэгийг дурьдвал:

-Хүн амын тоо 59 сая гэжээ. Энэ 15-20 жилийн өмнөх мэдээ байна.

-Үндэсний нийт бүтээгдэхүүнд ХАА-нх 28% эзэлдэг гэжээ. Мөн л олон жилийн өмнөх энэ үзүүлэлт одоо 60-аас дээш хувь болон өсчээ. /Шанхайд 2002 онд хэвлэгдсэн “Yatai fengqing Lu” номын 254-р тал/

-ХҮИ зууны 2-р хагаст испанчууд Филиппиний үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд тусгаар тогтносон БНФУ-ыг тунхагласан гэжээ. Гэтэл Филиппин 1898 онд тусгаар тогтносон, ХҮИ зуунд хувьсгалын тухай ойлголт ч гараагүй байв.

-1899-1901 оны америк-филиппиний дайнаар филиппинийг АНУ-ын хараат болгожээ гэж байна. Гэтэл түүхэнд испани-америкийн дайн гэж орсон байдаг.

-Нэг танхимтай үндэсний хурал хууль тогтоох зарим эрх эзэлдэг гэж бичжээ. Гэтэл Филиппиний Үндсэн хууль ёсоор тус оронд 2 танхимтай парламент ажилладаг. Энэ мэтчилэн үг үсэг, орчуулга, найруулгын алдаа мадаг олон байна.

Зөвхөн ганц улсаар жишээлэхэд ийм тохиолдол гарсан юм болов уу гээд бусад улс орны тухай сөхөн харвал мөн л эгээ адил ажээ.